

**Нэгдсэн үндэстний байгууллагын Суурин зохицуулагч,
НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч
Хатагтай Биата Транкман**

Эрхэмсэг ноён, Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх

Эрхэмсэг ноён, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Л.Оюун-Эрдэнэ

Хүндэт оролцогчид, ноёд, хатагтай нараа,

Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Монгол Улсын иргэн бүрт үйлчлэх төрийн албаны талаар хэлэлцэж байгаа энэ зөвлөгөөнд твтай морилно уу.

Орон нутгийн удирдлага, үүний дотор сум, хорооны Засаг дарга нар улс орны хөгжилд маш том үүрэг гүйцэтгэдэг. Тэд Засгийн газрын хамгийн яаралтай ажлыг нугалж, авсан амлалтыг газар дээр нь хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Засаг захиргааны энэ түвшинд эрүүл мэнд, боловсрол зэрэг хүн амд үзүүлэх үйлчилгээг хүргэж, үндэсний зорилтыг орон нутгийн бодит байдал болгон буулгадаг.

Төрийн албаны тухай хууль 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Уг хууль нь тогтвортой, улс төрийн хувьд төвийг сахисан, Монгол Улсын иргэдэд өндөр чанартай үйлчилгээ хүргэх чадвартай төрийн албыг төлөвшүүлэх зорилготой. Энэ зорилгыг хэрэгжүүлэгчид нь орон нутгийн удирдагчид Та бүхэн билээ.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд уг хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг маш амжилттай зохион байгуулсанд хувиасаа баяр хүргэе. Хуулийг дагалдаж гарах ихэнх журам батлагдаад байгаа. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд, төрийн албан хаагчдын бэлэн байдлыг шалгах зорилготой үндэсний хэмжээний ажлыг саяхан зохион

байгуулсан. Энэ ажлын үр дүнд төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн удирдлага, төрийн албан хаагчдын техникийн мэдлэгийн талаар маш чухал тоо баримт, өгөгдлүүдийг цуглуулж чадсан.

НҮБХХ энэхүү ажлыг хөндлөнгөөс нь ажиглаад зогсохгүй төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх энэ алхамд биечлэн оролцох завшаан тохиолдсонд туйлын баяртай байгаа. Гэвч **бидний урьд байгаа гол сорилт нь хуулийн хэрэгжилт** юм. Өөрчлөлтийг дээрээс эхэлж, өөрчлөлт түвшин бүрт хүрэх ёстой. Өөрчлөлтийг **итгэлцлийг бий болгох** замаар хэрэгжүүлэх шаардлагатай.

Дэлхий нийтээр засгийн газрууд иргэдийн хүлээлтийг хангах, олон нийтийн итгэл суларсан байдлыг залруулахад бүх хүчин чармайлтаа дайчилж байна. Иргэд төр засгийн удирдлагуудад улам бүр итгэхээ больсон бөгөөд тэд зөвхөн ажлын сайн үр дүн харуулж байж итгэлийг нь олж авах байнгын шахалтанд байх болсон.

Мэргэшсэн, орчин үеийн, үр ашигтай төрийн алба олон нийтийн итгэлийг бий болгож чадна. Төрийн албан хаагчид иргэдтэй хэрхэн харилцаж байгаа, төрийн бодлогыг тодорхойлоход иргэдийн оролцоо нээлттэй эсэх нь төр засгийн легитим байдлыг иргэд хүлээж авахад шууд нөлөөлдөг. Хууль дээдлэх ёсыг мөрдүүлэх, захиргааны үйл ажиллагааны шударга байдал төр засагт итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Хариуцлагыг чангатгахын зэрэгцээ ил тод байдал, төрийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээнд иргэдийн оролцоотой хяналтыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд төрийн албанд бүх иргэдийн төлөөлөл, үүний дотор эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл байх хэрэгтэй.

Итгэлцлийг бий болгоход төрийн алба мерит зарчмыг баримталдаг, ёс зүйтэй байх хэрэгтэй. Төрийн албаны ёс зүй, мерит тогтолцоог сайжруулах нь чухал зорилтууд бөгөөд Төрийн албаны тухай хуульд тусгалаа олсон. Гэхдээ эдгээрийг бодлогын тунхаглалаас илүү сонгон шалгаруулалт, томилгоо, албан тушаал дэвшүүлэх, ажлын үр дүнг үнэлэх, урамшуулал, шийтгэл, ёс зүйн дүрэм гэх мэт хүний нөөцийн удирдлагын

бүхий л шатанд мөрдөгдөх журам болгож, практикт хэвшүүлэх шаардлагатай.

Эндээс томоохон үр дүн хүлээж болно. Төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, мэргэшүүлэх, албан тушаал дэвшүүлэх ажиллагаа шударга, чадахуйн зарчимд үндэслэж явагдах юм бол ажиллагсдын урам зориг, итгэл үнэмшил, ажлын бүтээмж сайжирна. Авлига багасч, төрийн үйлчилгээний чанар сайжирч, илүү үр ашигтай болно.

Монгол Улсад эдгээр үр дүнг дэмжсэн тогтолцоог бүх шатанд бүрдүүлэх хэрэгтэй байна. Үүний нэг нь төрийн албанд танил талаараа биш өрсөлдөөний дагуу элсэх явдал юм. Энэ нь бас төрийн албан хаагчдыг тохиолдлын журмаар чөлөөлөгдөхөөс хамгаалах учиртай.

Засгийн газар энэ жилийг иргэн төвтэй төрийн албаны жил болгон зарласанд би баяртай байна. Төрийн албан хаагчдыг энэ зорилгыг биелүүлэхэд шаардлагатай ур чадвартай, ажил үүргээ итгэлтэй гүйцэтгэдэг болгох нь энэ зорилгыг биелүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Энэ зорилгын үүднээс НҮБХХ Удирдлагын академид сургалтын хөтөлбөрөө шинэчлэхэд нь дэмжлэг үзүүлж байгаа. Улсын болон хувийн салбарын аль алинд удирдах албан тушаалтнуудад хүмүүс хоорондын харилцааг зохицуулах, зөвшилцөл бий болгох, удирдан зохион байгуулах, харилцаа, багаар ажиллах зэрэг “уян ур чадвар”-ыг онцлох болсон. Төрийн албаны менежерүүдийн энэ шинж чанарыг хөгжүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр өөрчлөгдөнө гэж найдаж байна.

УИХ-ын Тамгын газар, НҮБХХ хамтран Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх” судалгааны ажлыг захиалан гүйцэтгүүлсэн. Төрийн үйлчилгээг үр нөлөөтэй хүргэхийн тулд аймаг, нийслэлд төвлөрсөн эрх мэдэл, төсвийн хөрөнгийг сум, дүүрэгт шилжүүлэх замаар **сумыг нутгийн удирдлагын цөм нэгж болгон бэхжүүлэх шаардлагатай хэмээн судалгааны гол дүгнэлт гарсан.**

НҮБХХ Монгол Улсын төрийн албаны шинэтгэлд тусалж ирсэн урт хугацааны уламжлалтай. Ардчилалд шилжих явцад Төрийн албаны тухай анхны хуулийг боловсруулахад дэмжлэг үзүүлж байсан. Монгол Улсын Төр засагтай өнөө хүртэл хамтран ажиллаж байгаагаараа бахархаж байна. Бидний хамгийн сүүлийн үеийн хамтын санаачилга бол 2022 он хүртэл хэрэгжих “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл юм. Энэ төслийг хэрэгжүүлэхэд харамгүй санхүүжилт гаргасан Канад Улсын Засгийн газарт талархал илэрхийлье.

Та жижиг хот, тосгоны захирагч байж болно. Гэхдээ та 2030 он хүртэлх ядуурлыг арилгах, тэгш бус байдлыг бууруулах, эх дэлхийн ирээдүйг хамгаалах Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх дэлхий нийтийн болон үндэсний үйл хэргийн чухал оролцогч тал билээ. Монгол Улс нэгдэн орсон энэ зорилтууд хэнийг ч үл үлдээхийг зорьж буй. Энэ нь төрийн алба хүн бүрт тэгш үйлчлэх хэрэгтэй гэсэн үг юм.

Эдгээр боломжийг нээж илрүүлэх өнөөдрийн хэлэлцүүлэгт амжилт хүсье. Баярлалаа.